



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 141

Шивээговь сум

Хязгаарлалтын дэглэмийг цуцалж
хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.5, 17 дугаар зүйлийн 17.2, 17.3, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хорио цээр хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 4,2 дах заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2 дугаар багийн малчин Мөнхбаатарын Билэгдэмбэрэлийн малд бог малын гоц халдварт мялзан өвчин гарсан нь Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн 23-3691 дугаартай шинжилгээгээр баталгаажсан тул 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн, голомтын бүсийг 6 километр, сэжигтэй бүсийг 9 километр, хамгаалалтын бүсийг 12 километр тогтоож газарт 21 хоногийн хугацаанд хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсээс гадагш гарах, орох хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг зогсоосугай.

3. Бог малын мялзан өвчин гадагш тархахаас хамгаалж, хорио цээрийн дэглэм сахиулах, голомтын бүсэд ажиллах, хяналтын постод техник, хэрэгсэл, хүн хүч дайчлан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д, шаардагдах зардлыг зохих журмын дагуу ОНХСангийн гамшгийн эрсдлийг бууруулах арга хэмжээний зардлаас гаргахыг санхүү төрийн сангийн мэргэжилтэн (Д.Өлзийсүрэн), нягтлан бодогч (Л.Цэнд-аюуш) нарт зөвшөөрсүгэй.

4. Малчин өрхийн отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөний нөхцөл байдалд тандалт хийж, малын эмчийн зөвшөөрөлгүй отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийхгүй байх, гадны аймаг сумдаас отор нүүдлээр хээлтүүлэгч мал, хурдан морь бусад мал, амьтан худалдаж авахгүй байхыг анхааруулж мэдэгдэхийг Бэхт багийн засаг дарга (Д.Маналмаа)-д, бог малын мялзан өвчин халдварласан байж болзошгүй малд үзлэг, тандалт судалгаа хийж, тусгаарлах, ариутгал халдваргүйжүүлэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Х.Баярцэнгэл) нарт үүрэг болгосугай.

5. Хорио цээрийн дэглэмийн хугацаанд хяналтын постонд ажиллах мэргэжлийн багийг 1 дүгээр хавсралтаар, голомтын болон сэжигтэй бүсэд байгаа малчин өрхийн зураглалыг 2 дугаар хавсралтаар, төв штаб дээр ажиллах албан хаагчдын нэрсийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай

6. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан сумын онцгой комиссыг ерөнхий удирдлага зохион байгуулалтаар хангаж, үүрэг даалгавар өгч, хэрэгжүүлэн ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Ч.Сугармаа)-д, штабыг өдөр тутмын шуурхай үүрэг, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал) нарт даалгасугай.

7. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/64 тоот захирамжийг хүчингүй болгосугай

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ





Сумын Засаг даргын 2023 оны 05 сарын 19-ны өдрийн А/х С. Энх-эрдэнэ захирамжийн хавсралт -1

ХЯНАЛТЫН ПОСТ АЖИЛЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ХУВААРЬ

№	Байгууллагын нэр	Хариуцах албан тушаалтны овог нэр	Эрхэлж буй ажил	Утасны дугаар	Постонд гарах хугацаа
1	Аймгийн Онцгой байдлын газар	А/х С. Энх-эрдэнэ	Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн	91047188	05.20-06.10
2	Аймгийн Цагдаагийн хэлтэс	Цагдаагийн хошууч Б.Шинэбаяр	Сумын Цагдаагийн хэсгийн дарга	99595934	05.20-06.10
3	Сумын мэргэжлийн анги туслах ажилтан	Засаг даргын Тамгын газар Д.Отгонжаргал	Тамгын газрын дарга	88116503	05.20-06.10



Сумын Засаг даргын 2023 оны 05-р сарын 19-ны өдрийн АА. Дугаар захирамжийн хавсралт -3

ТӨВ ШТАБ -Д АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Байгууллагын нэр	Хариуцах албан тушаалтны овог нэр	Эрхэлж буй ажил	Утасны дугаар	Постонд гарах хугацаа
1	Засаг даргын Тамгын газар	Д.Отгонжаргал	Засаг даргын Тамгын газрын дарга	88116503	05.20 05.21 06.08
2	Эрүүл мэндийн төв	Х.Сувданцэцэг	Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	80040349	05.22 05.23 06.09
3	Шивээ-Овоо ХК	Ц.Амарсайхан	ХАБЭАХ дарга	94059920	05.24 05.25
4	Ерөнхий боловсролын сургууль	С.Энхцэцэг	3-р сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч	99785089	05.27 06.08 06.02
5	3-р цэцэрлэг	Б.Даваадолгор	3-р цэцэрлэгийн эрхлэгч	96663805	05.28 06.10 05.31
6	"Шивээ-Овоо" ХК	Ц.Амарсайхан	ШОХК-н ХАБЭАХ-ийн дарга	94059920	05.29 05.30
7	"Илчлэг Шивээ" ААТОНӨҮГ	Ш.Чинболд	"Илчлэг Шивээ" ААТОНӨҮГ-ын захирал	96056446	06.01 05.26 06.06
8	Соёлын төв	Л.Түмэнцэцэг	Соёлын төвийн дарга	99813339	06.03 06.04
9	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Б.Базаррагчаа	ИТХ-ын нарийн бичгийн дарга	99711038	06.05 06.07